



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЗАХИАЛГАТ “ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬ, ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ” СЭДЭВТ НИЙЦЛИЙН АУДИТ



**ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН
ХЭРЭГЖИЛТЭД ТАВИХ ХЯНАЛТ
САЙЖИРСАН БАЙНА.**

АГУУЛГА

<p><u>Тайланг бэлтгэсэн:</u></p> <p>Дорноговь аймаг дахь төрийн аудитын газар</p> <p>Дарга, Тэргүүлэх аудитор Ч.Ариунаа</p> <p>Аудитын менежерийг түр орлон гүйцэтгэгч Ц.Лүндэгмаа</p> <p>Аудитор Б.Уранбилэг</p> <p>2018 оны 06 сарын 27</p> <p>Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах асууж лавлах зүйл байвал 70523020 дугаарын утас 70522734 дугаарын факсаар харилцана уу.</p> <p>ХАЯГ:</p> <p>Дорноговь аймаг Сайншанд сумын 3-р баг Орон нутгийн өмчийн 3 дугаар байр</p>	<p>Товчилсон үгийн тайлбар 2</p> <p>Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй 3</p> <p>Бүлэг 1. Газрыг хууль тогтоомжид заасны дагуу олгож, эзэмшүүлж, ашиглуулж байна.</p> <ul style="list-style-type: none"> - Сумдууд газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт хангалттай байна. - Үйлдвэрлэл үйлчилгээний зориулалтаар олгосон газарт байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийгдээгүй байна. - Газрыг хууль болон газрын дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтын зарчмыг баримтлан олгосон байна. - Газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааны болон төсөл сонгон шалгаруулалтын үнийг орон нутгийн төсөвт бүрэн төвлөрүүлсэн байна. - Газар эзэмших гэрээг жил бүр дүгнээгүйгээс хэрэгжилт хангалтгүй байна. <p>Бүлэг 2. Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх үйл ажиллагаа тус аймагт 25 хувийн хэрэгжилттэй байна.</p> <ul style="list-style-type: none"> - Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газрыг үнэгүй өмчлөх тухай хуулийн заалтын хэрэгжилт тус аймагт 25 хувийн биелэлттэй байна. - Иргэдэд хуулиар зөвшөөрөгдсөн газарт өмчлөх эрхийг олгож, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллажээ. - Иргэдэд газрыг хуульд заасан хэмжээг баримтлан өмчлүүлэхээр олгосон байна. - Иргэдээс ирүүлсэн өргөдлийг хууль, журмын дагуу шийдвэрлэж, хариуг хүргүүлсэн байна <p>Бүлэг 3 Газрын тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналт сайжирсан байна.</p> <ul style="list-style-type: none"> - Хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд холбогдох албан тушаалтан газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна. - Иргэд, олон нийтэд газрын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг мэдээлж ажилласан байна. <p>Дүгнэлт..... 27</p> <p>Зөвлөмж 28</p> <p>Холбогдох байгууллагын санал:..... 30</p> <p>Аймгийн Аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторын тушаал 31</p>
--	--

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
СИТХ	Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
БОАЖГ	Байгаль орчин, аялал жуулчлалын газар
БХБ	Барилга хот байгуулалт
ЗТХБС	Зам тээвэр хот байгуулалтын сайд
ГЗБГЗЗГ	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар
ААНБ	Аж ахуй нэгж, байгууллага
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх: Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн А/106 дугаар тушаалаар батлагдсан 2018 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө, Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын төлөвлөгөөний дагуу, Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд, аймгийн ИТХ-ын захиалгаар хийж гүйцэтгэлээ.

Аудитын зорилт: Газрын тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтэд аудит хийж, дүгнэлт зөвлөмж боловсруулан дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ.

Уг зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын дагуу аудит хийгдлээ. Үүнд:

1. Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хууль, журмын дагуу боловсруулж, мөрдөж ажилласан уу?
2. Газрыг хуульд заасны дагуу өмчлүүлж байна уу?
3. Газрын тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хууль журмын дагуу хяналтыг хэрэгжүүлж, мэдээллийг ил тод мэдээлж, ажилласан уу?

Аудитын хамарсан хүрээ: Аудитад аймгийн ГХБХБГ, аймгийн ИТХ болон Айраг, Даланжаргалан, Өргөн сумдын ИТХ, ЗДТГ-ыг хамруулан 2015-2017 онуудын газар зохион байгуулалт, газрын төлөвлөлт, газар олголт, дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтыг хууль журамд заасны дагуу зохион байгуулсан эсэх, дуудлага худалдааны орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байдалд аудитыг чиглүүллээ.

Аудитын арга зүй: Аудитын явцад аудит хийгдэж буй байгууллагын зарим албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, холбогдох судалгаа авах, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг ашиглахаас гадна Төрийн хяналт шалгалтын стандарт, гарын авлагад дурдсан аудитын арга зүйг мөрдөж, аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд: Дараах хууль эрхийн актуудыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

- Газрын тухай хууль
- Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль
- Газрын төлбөрийн тухай хууль
- Хот байгуулалтын тухай хууль
- Барилгын тухай хууль
- Чөлөөт бүсийн тухай хууль
- Хилийн тухай хууль
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
- Засгийн газрын 1997 оны 152 дугаар тогтоол

- Засгийн газрын 2003 оны 28 дугаар тогтоол
- Засгийн газрын 2010 оны 206 дугаар тогтоол
- Засгийн газрын 2015 оны 234 дүгээр тогтоол
- Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоол
- ГХГЗЗГ-ын даргын 2008 оны 83 дугаар тушаал

Аудит хийж гүйцэтгэсэн бүрэлдэхүүн:

Аудитыг дарга, тэргүүлэх аудитор Ч.Ариунаа хянан удирдаж, үе шатны хяналтыг аудитын менежерыг түр орлон гүйцэтгэгч Ц.Лүндэгмаа гүйцэтгэж, аудитор Б.Уранбилэг 2018 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс 06 дугаар сарын 27-ыг хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэв.

ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

БҮЛЭГ 1

Газрыг хууль тогтоомжид заасны дагуу олгож,
эзэмшүүлж, ашиглуулж байна.

1.1 Сумдууд газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт хангалттай байна.

Дорноговь аймагт 2017 оны жилийн эцсийн байдлаар 708790.6 га газрыг нийт 30081 иргэн, ААНБ эзэшиж, ашиглаж, өмчилж байна. Үүний 0.4 хувь буюу 2731.8 га газар нь өмчлөлийн, 83 хувь буюу 588632.7 га газар нь эзэмшлийн, 16.6 хувь буюу 117426.1 га газар нь ашиглалтын зориулалттай байна.

Аудитад хамрагдсан 3 сумдын хувьд нийт газар нутгийн хэмжээнийхээ 3-18.7 хувийг эзэмшил, ашиглалт, өмчлөлөөр ашигласан байна. /Хүснэгт №1/

Айраг, Даланжаргалан, Өргөн сумдын газрын ангилал /мян.га/

№	Сумын нэр	Нийт газар нутгийн хэмжээ	Үүнээс			Нийт ашиглагдаж байгаа газрын хэмжээ
			Эзэмшлийн газар	Ашиглалтын газар	Өмчлөлийн газар	
1	Айраг	744.3	0.73	5.30	0.11	6.1
2	Даланжаргалан	404.6	0.45	18.17	0.08	18.7
3	Өргөн	869.8	0.65	2.34	0.04	3.0
Нийт дүн		2018.7	1.83	25.81	0.23	27.87

Хүснэгт №1

Газрын тухай хуульд газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөг тухайн шатны Засаг даргын өргөн мэдүүлснээр Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд нийцүүлэн батлана. Батлагдсан төлөвлөгөөний дагуу газрыг иргэн, ААНБ-д зохих журмын дагуу эзэмшүүлж, ашиглуулахаар заасан байна.

2015-2017 онд газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд Айраг сум 449 иргэн, ААНБ-д 1500.1 га газрыг олгохоор төлөвлөснөөс 297 иргэн, ААНБ-д 1477.1 га газрыг, Даланжаргалан сум 157 иргэн, ААНБ-д 558.9 га газрыг олгохоор төлөвлөснөөс 139 иргэн, ААНБ-д 489.5 га газрыг, Өргөн сум 60 иргэн, ААНБ-д 709.8 га газрыг олгохоор төлөвлөснөөс 78 иргэн, ААНБ-д 301.3 га газрыг эзэмшүүлж, ашиглуулсан байна.

Газрын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4-т “сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө нь жилдээ хэрэгжүүлэх зураг төслийн баримт бичиг байна” гэж заасныг Айраг, Өргөн сумд баримтлан газар олгосон байна.

Харин Даланжаргалан сум 2015 онд газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдаагүй нийт 6 ААНБ-д 357.5 га газрыг сумын Засаг даргын шийдвэрээр олгосон байна. Эдгээрийг дурьдвал:

- Сумын Засаг даргын 2015 оны А/17 дугаар захирамжаар СЗДТГ-т “Цогцолбор”-ын эзэмшлийн зориулалтаар 2 га газар,
- Сумын Засаг даргын 2015 оны А/114 дугаар захирамжаар СЗДТГ-т “Албан контор”-ын эзэмшлийн зориулалтаар 0.3 га газар,
- Сумын Засаг даргын 2015 оны А/114 дугаар захирамжаар СЗДТГ-т “Хүүхэд залуучуудын парк”-ын эзэмшлийн зориулалтаар 0.33 га газар,
- Сумын Засаг даргын 2015 оны А/114 дугаар захирамжаар сумын Соёлын төвд “Соёлын төв”-ын эзэмшлийн зориулалтаар 0.06 га газар,
- Сумын Засаг даргын 2015 оны А/114 дугаар захирамжаар сумын Их Уулын говь ХХК-д “Шатахуун түгээх станц”-ын эзэмшлийн зориулалтаар 0.15 га газар,
- Сумын Засаг даргын 2015 оны А/34 дугаар захирамжаар сумын Дүншинхэние ХХК-д “Ашигт малтмал олборлох” ашиглалтын зориулалтаар 354.7 га газар,

Мөн Өргөн сумын 2016 оны газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөг 24 иргэн, ААНБ-д 522.8 га газрыг олгохоор төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр 20 иргэн, ААНБ-д 149.6 га газар олгосон нь нийт төлөвлөсөн газрын 29 хувийг эзэлж байна. Тус төлөвлөгөөнд 60 га газрыг судалгааны төвийн, 313 га газрыг аялал жуулчлал, ногоон байгууламжийн зориулалтаар эзэмшүүлэхээр төсөл сонгон шалгаруулалт зарласан боловч оролцогч ирээгүй шалтгаанаар хэрэгжээгүй байна.

1.2 Үйлдвэрлэл үйлчилгээний зориулалтаар олгосон газарт байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийгдээгүй байна.

Газрын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2-т “*Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар газар эзэмших эрх авсан иргэн, ААНБ нь 90 хоногт багтаан байгаль орчны нөлөөллийн үнэлгээг хийлгэсний дараа газар эзэмших гэрээ байгуулж, эрхийн гэрчилгээ олгоно, ...*”, мөн хуулийн 34 дүгээр зүйлийн 34.3-т “*байгаль орчныг үнэлгээ нь сөрөг дүгнэлттэй гарвал эрхийн гэрчилгээг олгохоос татгалзаж, дуудлага худалдааны үнийг буцаан олгоно*” гэж тус тус заасан байна.

Айраг, Даланжаргалан, Өргөн сумдад 2015-2017 онуудад үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар нийт 104 иргэн, ААНБ-д 216.3 га газрыг эзэмшүүлэх гэрээ байгуулан, эрхийн гэрчилгээг олгосон.

Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ гэдэг нь “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуульд зааснаар “... *иргэн, ААНБ-аас тодорхой төслийг хэрэгжүүлэх явцад байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл, үр дагаврыг урьдчилан тодорхойлж, түүнийг бууруулах, арилгах арга хэмжээ тогтоохыг хэлнэ*” гэж заажээ.

Гэтэл 2015-2017 онуудад Айраг, Даланжаргалан, Өргөн сумдад нийт 8 иргэн, ААНБ 0.4 га газарт аймгийн БОАЖГ-аар байгаль орчны үнэлгээг хийлгэсэн байна. Энэ нь үйлдвэрлэл үйлчилгээний зориулалтаар дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтаар газар эзэмшсэн нийт газрын 0.2 хувийг эзэлж байна.

Энэхүү нөлөөллийн үнэлгээг үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар газар эзэмших эрх авсан тухайн иргэн, ААНБ нь” Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль”-ийн хавсралтад заасан ангиллын дагуу, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн

захиргааны төв байгууллага, эсхүл байгаль орчны албанд холбогдох баримтыг бүрдүүлэн, хийлгэнэ гэж заасан байна.

Аймгийн БОАЖГ уг нөлөөллийн үнэлгээг хийлгэх тухай хүсэлт гаргасан иргэн, ААНБ-аас холбогдох баримтыг бүрдүүлэн авч, 1-7 хоногийн хугацаанд шийдвэрлэдэг байна.

Айраг, Даланжаргалан, Өргөн сумдын хувьд уг нөлөөллийн үнэлгээг хийлгээгүй байгаа нь Газрын тухай хууль болон бусад холбогдох хуулийг зөрчиж байгаагаас гадна эзэмшүүлсэн газар болон тухайн иргэн, ААНБ-ын үйл ажиллагаа нь байгаль орчинд нөлөөлөх байдлаар сөрөг байх эрсдэлийг бий болгож байгаа юм.


Сумдын газрын мэргэжилтнүүд иргэн, ААНБ-д газар эзэмших эрх олгож, гэрээ байгуулахдаа нөлөөллийн үнэлгээг харгалзан үзэхгүй байгаа нь Газрын тухай хуулийн 34 дүгээр зүйлд заасан “Газар эзэмших гэрээ, түүнийг байгуулах журам”-ыг зөрчиж байна.

1.3 Газрыг хууль болон газрын дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтын зарчмыг баримтлан олгосон байна.

Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2-т иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар 0.07 га, хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалахад 0.1 га-аас илүүгүй, давуу эрхээр эзэмшүүлэх үр тарианы зориулалтаар 100 га хүртэл, хүнсний ногооны зориулалтаар 5 га хүртэл хэмжээгээр газар эзэмшүүлэхээс бусад зориулалтаар болон тогтоосон дээрх хэмжээнээс илүү газар эзэмших асуудлыг тухайн шатны Засаг дарга дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулах зарчмаар шийдвэрлэнэ гэж заасан байна. Уг газрын дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулах журмыг Засгийн газрын 2003 оны 28 дугаар тогтоол, 2016 оны 10 дугаар тогтоолоор тус тус журамласан байна.


2015-2017 онд Айраг суманд 28 иргэн, ААНБ-д 146.9 га газар, Даланжаргалан суманд 20 иргэн, ААНБ-д 32.9 га газар, Өргөн суманд 35 иргэн, ААНБ-д 27.9 га газрыг үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар олгожээ. Нийт олгосон газрын 42 хувийг газар эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдааны, 58 хувийг төсөл сонгон шалгаруулах зарчмыг баримтлан олгосон байна. /График №1, 2/

График №1



Дуудлага худалдааны зарчмаар эзэмшүүлсэн газар /га/

График №2



Төсөл сонгон шалгаруулалтын зарчмаар эзэмшүүлсэн газар /га/

Газрын тухай хууль болон газрын дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулах журмыг зөрчиж, үйл ажиллагаа явуулж байгаа дараах асуудлууд илэрч байна. Үүнд:

- Өргөн сумын Засаг даргын 2015 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн А/11 дугаар тушаалаар иргэн У.Баяртогтоход 0.5 га газрыг худалдаа үйчилгээний зориулалтаар, дуудлага худалдааны зарчмаар олгожээ. Гэтэл уг газрыг иргэн А.Буяннэмэхэд сумын Засаг даргын 2015 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 58 дугаар захирамжаар тухайн газрыг ШТС-ын зориулалтаар өөрчлөн эзэмших эрхийг шилжүүлсэн байна. Энэ нь Газрын тухай хуулийн 35.1.1-д “... газар эзэмшигч нь гэрээнд заасан зориулалтын дагуу эзэмшиж ашиглана...” гэж заасантай нийцэхгүй байна.
- Айраг сумын иргэн О.Энхээ нь эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр гэр бүлийн хэрэгцээний газраас илүү газарт өргөтгөл барьж, худалдаа үйлчилгээний зориулалтаар ашиглаж байна. Энэ нь Газрын тухай хуулийн 33.1.1-д “... газрыг эзэмшүүлэх тухай шийдвэрийг аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталсан газар зохион байгуулалтын ерөнхий болон тухайн жилийн төлөвлөгөөний дагуу тухайн шатны Засаг дарга гаргана” гэж заасантай нийцэхгүй байна.
- Даланжаргалан сумын иргэн Э.Мөнхзаяа нь сумын Засаг даргын 2005 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 39 дугаар захирамжаар 0.06 га газрыг гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар эзэмшжээ. Уг газарт одоогийн байдлаар худалдаа үйлчилгээний зориулалтаар хүнсний дэлгүүр ажиллуулж байна. Засаг даргын дээрх захирамжид газар эзэмших эрх олгосон эсэхийг хянаж үзэхэд иргэнд дээрх газрыг эзэмшүүлсэн тухай тусгаагүй байна. Энэ нь газрын тухай хуулиар газар эзэмших эрх олгосон эсэхийг нотлох боломжгүй байна.



Иймд тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй болон эрх бүхий албан тушаалтны шийдвэргүй, зориулалт өөрчилж эзэмшүүлсэн газрыг хууль журамд заасны дагуу эзэмшүүлэх, ашиглуулах талаар холбогдох албан тушаалтанд зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

Мөн газрын дуудлага худалдаанд оролцогч, ялагч тодроогүй, төсөл сонгон шалгаруулалтад төсөл ирээгүй газрын баримт материал хангалтгүй, архивын нэгж бүрдүүлээгүй учраас уг төсөл сонгон шалгаруулалт, дуудлага худалдааг зохион байгуулсан эсэхийг нотлоход хүндрэлтэй байв.

1.4 Газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааны болон төсөл сонгон шалгаруулалтын үнийг орон нутгийн төсөвт бүрэн төвлөрүүлсэн байна.

Газрыг эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээний дуудлага худалдааны анхны үнийг тооцох аргачлал нь ЗТХБ-ын сайдын 2010 оны 206 дугаар тушаалаар батлагдсан ба БХБ-ын сайдын 2015 оны 12 дугаар сарын 234 дүгээр тушаалаар дахин шинэчлэгдэн батлагджээ.

Дээрх шинэчлэгдсэн аргачлалаар тооцоход газрын эзэмшил, ашиглалтын төрөл нь тухайн бүсээс хамааран дуудлага худалдаагаар эзэмшүүлэх 1м.кв газар нь аймгийн төв болох Сайншанд суманд 400-12000 төгрөг, бусад сумдад 80-960 төгрөгийн үнэлгээтэй байна.

2015-2017 онд аудитад хамрагдсан сумдад нийт 76 иргэн, ААНБ-д 87.2 га газрыг дуудлага худалдааны зарчмаар олгон, анхны үнэ тооцох аргачлалын дагуу тооцож, 194.7 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна. /Хүснэгт №4/

2015-2017 онд Айраг, Даланжаргалан, Өргөн сумдад газрыг дуудлага худалдаанаас орон нутагт төсөвт төвлөрүүлсэн байдал

Хүснэгт №4

№	Сумын нэр	Он	Дуудлага худалдаа /мянган төгрөг/			Дутуу
			Анхны үнэ	Дуудлага худалдааны үнэ	Төсөвт төвлөрүүлсэн	
1	Айраг	2015	2,002.5	4,812.4	4,812.4	0
		2016	12,312.6	15,071.8	15,071.8	0
		2017	2,272.0	6,228.8	6,228.8	0
2	Даланжаргалан	2015	4,128.9	6,360.2	6,360.2	0
		2016	1,345.9	1,600.4	1,600.4	0
		2017	55,680.0	75,080.0	75,080.0	0
3	Өргөн	2015	3,254.7	3,866.1	3,866.1	0
		2016	2,934.7	4,308.6	4,308.6	0
		2017	71,316.2	77,325.2	77,325.2	0
Нийт дүн			155,247.5	194,653.5	194,653.5	-

Харин газрыг төсөл сонгон шалгаруулалтаар олгоход газрын үнийг тооцох тодорхой аргачлал батлагдаагүй байна. Ийм учраас газрыг төсөл сонгон шалгаруулалтын зарчмаар олгохдоо дуудлага худалдааны анхны үнэ тооцох аргачлалаар тооцон, уг дүнг гурав дахин нэмэгдүүлж төслийн баримт бичгийг боловсруулжээ. Энэхүү аргачлал нь хууль болон бусад эрх бүхий албан тушаалтнаар батлагдаагүй байна.

2015-2017 онд нийт 7 иргэн, ААНБ-д 120.5 га газрыг төсөл сонгон шалгаруулалтаар олгосон байна. Эдгээр сонгон шалгаруулалтын үнийг газрын дуудлага худалдааны анхны үнэ тооцох аргачлалын дагуу тооцож, орон нутгийн төсөвт 781.3 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна. /Хүснэгт.№5 /

2015-2017 онд Айраг, Даланжаргалан, Өргөн сумдад төсөл сонгон шалгаруулалтаас орон нутагт төсөвт төвлөрүүлсэн байдал

Хүснэгт №5

№	Сумын нэр	Он	Төсөл сонгон шалгаруулалт /мянган төгрөг/		Илүү дутуу
			ТСП-ын үнэ	Төсөвт төвлөрүүлсэн дүн	
1	Айраг	2015	96.0	96.0	0.0
		2016	12,000.0	12,000.0	0.0
		2017	160,000.0	480,000.0	(320,000.0)
2	Даланжаргалан	2015	6,000.0	6,000.0	0.0
		2016	-	-	-
		2017	283,200.0	283,200.0	0.0
3	Өргөн	2015	-	-	-
		2016	-	-	-
		2017	-	-	-
Нийт дүн			461,296.0	781,296.0	(320,000.0)

Дээрх судалгаанаас харахад Айраг суманд 2017 онд 320.0 сая төгрөгийг илүү төвлөрүүлсэн байна. Энэ нь сумын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөний дагуу 40 га газрыг нарны цахилгаан станцын зориулалтаар эзэмшүүлэхээр төсөл сонгон шалгаруулалтыг зарлажээ. Уг төслийн үнийг 160.0 сая төгрөг /дуудлага худалдааны анхны үнэ тооцох аргачлалаар/ баримт бичгийг боловсруулан, газрын биржийн цахим системд байршуулсан байна. Газрыг олгохдоо газрын үнийг төсөл сонгон шалгаруулах одоогийн баримталж байгаа зарчмаар 3 дахин нэмэгдүүлэн 480.0 сая төгрөгөөр тооцож орон нутгийн төсөвт төвлөрүүлснээс дээрх зөрүү үүсчээ.

2015-2017 онуудад аудитад хамрагдсан сумдад газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааны болон төсөл сонгон шалгаруулалтын үнийг иргэн, ААНБ-ууд журамд заасан хугацаанд бүрэн төлж барагдуулсан байна.

1.5 Газар эзэмших гэрээг жил бүр дүгнээгүйгээс хэрэгжилт хангалтгүй байна.

Газрын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.1-д “ ... газар эзэмшигч нь гэрээнд заасны дагуу газрыг зориулалтын дагуу эзэмших, ашиглах, 35.3.1-д “ гэрээнд заасан нөхцөл, болзлыг биелүүлэх” гэж тус тус заасан байна.

Аудитын явцад газар эзэмшилт, ашиглалтын байдлыг түүвэрлэн үзэхэд гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрын зарим хэсгийг бусад зориулалтаар ашиглаж байгаа зөрчил Айраг суманд илэрч байна. Тус сумын нэр бүхий 8 иргэн, 0.2 га газрыг гэрээнд зааснаас өөр зориулалтаар эзэмшиж байна. /Хүснэгт №6/

Газрыг зориулалт бусаар эзэмшиж буй иргэдийн судалгаа

Хүснэгт №6

№	Газар эзэмшигч иргэн, ААНБ-ын нэрс	Газрын зориулалт	Газрын хэмжээ /га/	Газар эзэмших эрх олгосон шийдвэр	Тайлбар
<i>Айраг сум</i>					
1	Г.Батмөнх	Төмс, хүнсний ногоо тарих галуу шувуу тэжээх	0.01	2012/12/27 А/217	Төмс, хүнсний ногооны тарих талбай хагалсан. Цайны газар ажилуулдаг
2	Б.Намжилсүрэн	Гэр бүлийн хэрэгцээ	0.01	2014/12/12 А/190	Өргөтгөл барьж хүнсний дэлгүүр ажиллуулдаг.
3	С.Молор-Эрдэнэ	Гэр бүлийн хэрэгцээ	0.01	2001/05/01 №30	Өргөтгөл барьж хүнсний дэлгүүр, цайны газар ажиллуулдаг.
4	Д.Улаанхүү	Гэр бүлийн хэрэгцээ	0.0062	2003/10/23 №38	Өргөтгөл барьж хүнсний дэлгүүр ажиллуулдаг.
5	Ч.Чинбалт	Гэр бүлийн хэрэгцээ	0.0054	2014/01/10 А/02	Өргөтгөл барьсан. Цэвэршүүлсэн ус ажиллуулдаг.
6	Ч.Чингэрэл	Гэр бүлийн хэрэгцээ	0.03	2014/01/10 А/02	Өргөтгөл барьж дэлгүүр ажиллуулдаг.
7	С.Энхтуяа	Гэр бүлийн хэрэгцээ	0.07	2014/01/27 А/11	Хүнсний дэлгүүр ажиллуулдаг.
8	Н.Гантуяа	Гэр бүлийн хэрэгцээ	0.05	2015/09/24 А/138	Түүхий эд авдаг.
Дүн			0.2		

Дээрх эзэмшсэн газраа гэрээнд зааснаас өөр зориулалтаар ашиглаж байгаа иргэдийн газрын асуудлыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу арга хэмжээ авч ажиллахыг эрх бүхий албан тушаалтанд зөвлөмжөөр хүргүүлэхээр шийдвэрлэв.

Мөн Газрын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.8-д “ ... гэрээний биелэлтийг талууд жил бүр дүгнэнэ” гэж заасан байна.

Аудитад хамрагдсан сумдын нийт газар нутгийн 27872.3 га газрыг эзэмшлийн зориулалтаар ашиглаж байна. Гэр бүлийн хэрэгцээ, үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай эзэмшлийн газар нь Айраг сум 11.9 хувь, Даланжаргалан сум 2.4 хувь, Өргөн сум 21.4 хувь байна. Эдгээр газрын эзэмших гэрээг нэг талаас эзэмшигч иргэн, ААНБ, нөгөө талаас газрын даамал нар жил бүр дүгнэх ёстой байна.

Гэтэл дээрх сумд 2015-2017 онуудад газар эзэмших гэрээг дүгнээгүй байна Харин 2018 онд Айраг сум 9 иргэний 0.3 га газрын, Даланжаргалан сум 4 ААНБ-ын 1.2 га газрын, Өргөн сум 9 иргэн, 37 ААНБ-ын 829.3 га газрын эзэмших гэрээг дүгнэжээ.

Газрын тухайн хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.6-д “... хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гэрээнд заасан зориулалтаар тухайн газраа 2 жил дараалан ашиглаагүй бол уг газрыг эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгоно” гэж заажээ.

Мөн дээрх хуулийн заалтыг Монгол Улсын дээд шүүхийн 2008 оны 15 дугаар тогтоолд “... хүндэтгэн үзэх шалтгаангүй ...” гэдгийг гэнэтийн давагдашгүй хүчний эсхүл байгалийн тогтолцооны өөрчлөлтөөс тухайн газарт нь эвдрэл, элэгдэл, цөлжилт бий болсон, бусдын хууль бус үйлдэл зэрэг эзэмшигчээс хамаарах шалтгаан байхгүй байсныг ойлгоно гэж тайлбарласан байна.

Айраг суманд 29 иргэн, ААНБ 88.1 га газар, Даланжаргалан сум 16 иргэн, ААНБ 182.7 га газар, Өргөн сум 23 иргэн, ААНБ 158.7 га газрын эзэмших эрхийн гэрчилгээ авч, гэрээ байгуулсан боловч хуульд заасан хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр 2 болон түүнээс дээш хугацаагаар ашиглаагүй байна. /Хавсралт №1/

Тухайлбал:

- Айраг сумын Засаг даргын 2009 оны А/100 дугаар захирамжаар "Босстон Интернэшнл" ХХК-д үйлдвэрлэлийн зориулалтаар 1 га газар, 2012.05.14 А/69 дугаар захирамжаар үйлдвэрлэлийн зориулалтаар 9 га газрыг эзэмшүүлсэн боловч үйл ажиллагаа явуулаагүй.



"Босстон Интернэшнл" ХХК-д эзэмшүүлсэн 10 га газар



Айраг сумын Засаг даргын 2011 оны А/150 тоот захирамжаар иргэн Ё.Цэрмаад зочид буудлын зориулалтаар 0.05 га газрыг олгосон боловч үйл ажиллагаа явагдаагүй.



Айраг сумын 2013 оны А/192 тоот захирамжаар сумын Ардчилсан намд албан конторын зориулалтаар 0.08 га газрыг олгосон байна. Үйл ажиллагаа одоо хүртэл явуулаагүй



Даланжаргалан сумын Засаг даргын 2015 оны А/49 дугаар захирамжаар “Мүүн Монголиа” ХХК-д зорчигч үйлчилгээний цогцолборын зориулалтаар 3 га газрыг олгосон боловч үйл ажиллагаа явуулаагүй.



Даланжаргалан сумын Засаг даргын 2014 оны А/141 дугаар захирамжаар “Тэнүүн байгаль” ХХК-д ачилт буулгалтын талбайн зориулалтаар 1 га газрыг олгосон боловч үйл ажиллагаа явуулаагүй.



Өргөн сумын Засаг даргын 2015 оны А/120-131 дугаар захирамжаар 13 иргэнд авто гражын зориулалтаар 0.05 га газрыг олгосон боловч үйл ажиллагаа явуулаагүй.



Өргөн сумын Засаг даргын 2015 оны А/110 дугаар захирамжаар иргэн Ч.Гүрбазарт үйлдвэрлэлийн зориулалтаар 0.009 га газрыг олгосон боловч үйл ажиллагаа явуулаагүй.

Дээрх зөрчилд газрын тухай хуульд заасны дагуу холбогдох арга хэмжээ ажиллахыг эрх бүхий албан тушаалтанд аудитын зөвлөмжөөр хүргүүлэхээр шийдвэрлэв.

Мөн Газрын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.6-д “... эзэмшилд авсан газрын 10-аас доошгүй хувийг ногоон байгууламжтай байлгана” гэж хуульчлан заажээ.

Гэтэл аудитад хамрагдсан сумдад дээрх хуулийн заалтыг хэрэгжүүлж ажиллах талаар арга хэмжээ авч ажиллаагүй, тодорхой ажил зохион байгуулаагүй байна. Эзэмшлийн газартаа ногоон байгууламжтай болгосон иргэн, ААНБ байхгүй байна.

**ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬ
ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ**

БҮЛЭГ 2

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх үйл ажиллагаа тус аймагт 25 хувийн хэрэгжилттэй байна.

2.1 Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар иргэнд газрыг үнэгүй өмчлөх тухай хуулийн заалтын хэрэгжилт тус аймагт 25 хувийн биелэлттэй байна.

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль нь 2002 оны 06 дугаар сарын 27-ны өдөр батлагдан, 2003 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөгдөж эхэлсэн байна. Уг хуульд 2018 оны байдлаар нийт 8 удаа нэмэлт өөрчлөлт орж, гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар олгох газрын хугацааг 3-10 хүртэлх жилээр 4 удаа сунгажээ /хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсэг/. УИХ-ын 2018 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр иргэнд газрыг үнэгүй өмчлүүлэх хугацааг 2028 он хүртэл олгохоор батлагдсан байна.

2017 оны жилийн эцсийн байдлаар тус аймагт ашиглагдаж буй нийт газар нутгийн 0.4 хувь буюу 2731.8 га газар нь өмчлөлийн зориулалттайгаар иргэдэд олгогдсон байна.

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 04 дүгээр зүйлд иргэнд газрыг “...гэр бүлийн хэрэгцээний болон аж ахуйн зориулалтаар” өмчлүүлэхээр хуульчилсан байна.

Уг хуульд заасны дагуу иргэний газар өмчлөх эрхийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан тус аймагт 2003-2017 онд нийт 16750 иргэнд 2731.4 га газрыг гэр бүлийн хэрэгцээний, 3 иргэнд 0.37 га газрыг аж ахуйн зориулалтаар өмчлүүлэхээр олгожээ. /Он дараалал тус бүрээр хүснэгт №7-д үзүүлэв/

2003-2017 онд газар өмчилсөн иргэдийн судалгаа

Хүснэгт №7

Д/д	Хамрах хугацаа	Газрын зориулалт				Нийт дүн	
		Гэр бүлийн хэрэгцээ		Аж ахуй		Иргэн	Газрын хэмжээ /га/
		Иргэн	Газрын хэмжээ /га/	Иргэн	Газрын хэмжээ /га/		
1	2003 он	217	37.7			217	37.7
2	2004 он	470	52.9			470	52.9
3	2005 он	2097	236.5			2097	236.5
4	2006 он	269	39.1			269	39.1
5	2007 он	407	47.0			407	47.0
6	2008 он	1065	224.4			1065	224.4
7	2009 он	329	32.8			329	32.8
8	2010 он	198	19.3			198	19.3
9	2011 он	1191	207.6			1191	207.6
10	2012 он	3044	629.4	2	0.34	3046	629.8
11	2013 он	1568	317.6			1568	317.6
12	2014 он	2781	488.1	1	0.03	2782	488.1
13	2015 он	1218	177.2			1218	177.2
14	2016 он	1273	153.0			1273	153.0

15	2017 он	620	67.8			620	67.8
Нийт		16750	2731.4	3	0.37	16753	2731.8

Дээрх судалгаа дахь газар өмчилсөн нийт иргэдийн /газар өмчлүүлэх шийдвэр гаргах үеийн хаяг, байршлаар/ 16 хувь буюу 2665 иргэн нь өөр аймаг, хотын харьяалалтай байна. Эдгээр иргэд тус аймгийн газар нутагт 67 га газрыг гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар үнэгүй өмчлөн авч, хуулиар олгосон эрхээ хэрэгжүүлжээ. /Газрын байршлыг хүснэгт №8-д үзүүлэв/

Өөр аймаг, хотын харьяалалтай иргэд тус аймагт гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газар өмчилсөн тухай судалгаа

Хүснэгт №8

№	Сумын нэр	Газар өмчлөгч	
		Иргэний тоо	Газрын хэмжээ /га/
1	Айраг	8	0.6
2	Сайншанд	2636	64.7
3	Даланжаргалан	13	0.9
4	Дэлгэрэх	4	0.4
5	Өргөн	4	0.4
Нийт		2665	67.0

Харин 2003-2017 онуудад тус аймгийн харьяалалтай 628 иргэн өөр аймаг, хотод газар өмчлөх эрхээ хэрэгжүүлэхээр аймгийн ГХБХБГ-аас тодорхойлолт, лавлагаа авсан байна.

Аймгийн Статистикийн хэлтсээс 2017 оны жилийн эцсийн байдлаар Дорноговь аймаг нь нийт 68192 хүн амтай гэсэн судалгаа гарсан. Уг судалгааг гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газар өмчилсөн тус аймгийн харьяалалтай иргэдийн тоотой харьцуулбал 21 хувь, харин нийт газар өмчилсөн иргэдийн тоотой харьцуулбал 25 хувь нь газраа өмчилсөн гэсэн судалгаа гарч байна. /Хавсралт №2 /

Мөн хуулийн 05 дугаар зүйлийн 5.1.4-т “ ... иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газрыг **нэг удаа** үнэгүй өмчлүүлнэ ” гэж заажээ.

Гэтэл аймгийн хэмжээнд 2003-2017 онд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар 6.7 га газрыг 25 иргэнд давхардуулан олгож, өмчлүүлсэн нь дээрх хуулийн заалттай нийцэхгүй байна. /Хавсралт №2-т харуулав /

Энэхүү гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газрыг дахин давхардуулан олгосон зөрчилд хууль, тогтоомжийн хүрээнд газар өмчлөх эрхийг хүчингүй болгох тухай *албан шаардлагыг* холбогдох албан тушаалтанд хариуцуулан тогтоохоор шийдвэрлэв.

2.2 Иргэдэд хуулиар зөвшөөрөгдсөн газарт өмчлөх эрхийг олгож, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллажээ.

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 06 дугаар зүйлийн 6.1.1-д “*хот тосгон, бусад суурины нутаг дэвсгэр дэх нийтийн эдэлбэрийн газар /гудамж, талбай, зам, амралт, зугаалга, биеийн тамирын зориулалттай газар, цэцэрлэг, оршуулгын газар, хог хаягдлын цэг, цэвэршүүлэх талбай зэрэг/, бэлчээр, ойн болон усны сан бүхий газар, тусгай хэрэгцээний газар, зам, шугам сүлжээний газраас бусад газарт иргэнд газар*

өмчлүүлж болно”. Мөн хуулийн 6.1.2-т тариалангийн талбай болон атаршсан газарт газар тариалангийн зориулалтаар газар өмчлүүлж болно гэж тус тус хуульчлан заажээ.

2003-2017 онд нийт 13 суманд хуулийн дээрх заалтын дагуу зөвшөөрөгдсөн газарт гэр бүлийн болон аж ахуйн зориулалтаар 16753 иргэнд 2731.8 га газрыг өмчлүүлэхээр олгосон байна

Эдгээр газрыг аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, аймаг, сумын хот хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу, иргэдийн хүсэлтэд үндэслэн, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлагдсан газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгаж, хууль тогтоомжид заасны дагуу олгон, хуулийг хэрэгжүүлж ажиллажээ.

Мөн Газрын тухай хуулийн 05 дугаар зүйлийн 5.2-т “Бэлчээр, нийтийн эдэлбэрийн ба улсын тусгай хэрэгцээнийхээс бусад газрыг зөвхөн Монгол Улсын иргэнд өмчлүүлж болно”, тусгай хэрэгцээний газар гэдэгт энэхүү хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.2-т зааснаар улсын хилийн зурвас газар, 16.1.9-д зааснаар чөлөөт бүсийн газар байна гэж тус тус заажээ.

Тус аймгийн Замын-Үүд сумыг Чөлөөт бүсийн тухай хуулийн 05 дугаар зүйлийн 5.1-д заасныг үндэслэн УИХ-ын 2004 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 17 дугаар тогтоолоор Замын-Үүд дэх боомтыг түшиглэн “Замын-Үүд чөлөөт бүс” болгон баталсан байна. Уг тогтоолоор чөлөөт бүсийн нийт газар нутгийн хэмжээг 900 га-аар тогтоож, хилийн зааг, эргэлтийн цэгийн солбилцлыг тодорхой заасан байна.

Мөн Монгол Улсын хилийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д “Улсын хилийн дэглэмийг сахиулах, улсын хил хамгаалалт, шалган нэвтрүүлэх албыг зохион байгуулах, хилийн инженер, техникийн байгууламж барих зориулалтаар улсын хилийн шугамаас дотогш 15 км-ээс илүүгүйгээр тусгай журам тогтоосон нутаг дэвсгэрийг улсын хилийн зурвас гэнэ” гэж заасан байна.



Замын-Үүд сум нь нийт 48.6 мянган га газар нутагтай байна. Уг газар нутаг нь улсын хилийн дагуу уртааш сунасан байршилтай учир хилийн зурвас газарт бүхэлдээ хамрагджээ. Иймд дээрх хууль тогтоомжид заасны дагуу тус сумын нутагт өмчлөлийн зориулалтаар газар олгох боломжгүй байна.

2.3 Иргэдэд газрыг хуульд заасан хэмжээг баримтлан өмчлүүлсэн байна.

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд “ ... газрыг гэр бүлийн зориулалтаар өмчлүүлэхдээ газрын байршил, зориулалтаас хамааран аймгийн төвд 0.35 хүртэл га буюу 3500 м.кв, сумын төвд 0.5 хүртэл га буюу 5000 м.кв, нийслэлийг аймгийн төвтэй холбосон улсын чанартай автозам дагуух газарт /сумын төвөөс бусад/ 0.07 га буюу 700 м.кв хүртэл хэмжээгээр олгоно” гэж хуульчилан, заасан байна.

2003-2017 онд нийт 13 суманд өмчлөлийн зориулалтаар газрыг 169-5225 м.кв хүртэл хэмжээгээр иргэдэд олгосон байна. Үүнийг сум тус бүрээр харуулбал дараах байдалтай байна. /Хүснэгт №9 /

Сумдад гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмчлүүлэхээр олгосон газрын хэмжээ

Хүснэгт №9

№	Сумдын нэр	Газрын хэмжээ /м.кв/	
		Доод хэмжээ	Дээд хэмжээ
1	Айраг	263	5000
2	Алтанширээ	503	2000
3	Даланжаргалан	300	5225
4	Дэлгэрэх	225	3380
5	Замын-Үүд	-	-
6	Иххэт	288	5000
7	Мандах	247	5000
8	Сайншанд	105	3500
9	Сайхандулаан	687	1225
10	Өргөн	449	2061
11	Улаанбадрах	400	1700
12	Хатанбулаг	169	5000
13	Хөвсгөл	500	5000
14	Эрдэнэ	216	5000

Дээрх судалгаанаас харахад Даланжаргалан суманд газрын хэмжээг хуульд зааснаас илүү олгосон байна. Энэ нь сумын Засаг даргын 2005 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 39 дугаар захирамжаар иргэн Б.Болдбаатарт гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар 5225 м.кв газрыг үнэгүй өмчлүүлсэн ба хуульд заасан хэмжээнээс 225 м.кв-аар илүү байна.

Иймд уг газрыг хуульд заасан хэмжээгээр олгож, илүү газарт дуудлага худалдаа зохион байгуулах тухай зөвлөмжийг холбогдох албан тушаалтанд хүргүүлэхээр шийдвэрлэв.

Монгол Улсын 2013 оны Төсвийн тухай хуулийн II хавсралтын ХХ.1.43, Засгийн газрын 2009 оны 25 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж нийт 11 сумын 897 нэгж талбарын 89.4 га газарт дахин хэмжилт хийж, өмчилж буй газрын бодит хэмжээгээр цахим программ дахь мэдээллийг шинэчлэсэн байна. /Хүснэгт №10/

Сумдад газрын хэмжилт хийсэн судалгаа

Хүснэгт №10

№	Сумдын нэр	Нэгж талбарын тоо	Газрын хэмжээ /га/	
			Захирамжаар олгосон	Бодит хэмжээ
1	Сайхандулаан	15	1.31	1.41
2	Хөвсгөл	6	0.77	0.61
3	Мандах	10	0.86	0.95
4	Дэлгэрэх	286	29.48	29.58
5	Иххэт	96	9.13	8.60
6	Алтанширээ	22	1.74	2.11
7	Өргөн	52	4.01	4.87
8	Эрдэнэ	64	7.36	5.78
9	Даланжаргалан	160	18.30	16.25
10	Айраг	182	15.26	17.26
11	Хатанбулаг	4	1.22	1.54
Нийт		897	89.44	88.96

2.4 Иргэдээс ирүүлсэн өргөдлийг хууль, журмын дагуу шийдвэрлэж, хариуг хүргүүлсэн байна

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.6-д “иргэнд газар өмчлүүлэх эрх бүхий Засаг дарга газар өмчилж авах тухай иргэний гаргасан өргөдлийг хүлээж авсан өдрөөс хойш 3 сарын дотор хянан шийдвэрлэнэ” гэж заасан байна.

2003-2017 онуудад аймгийн хэмжээнд газар өмчлөлтэй холбоотой нийт 17795 иргэнээс өргөдөл хүсэлтийг хүлээн авсан байна. Нийт ирүүлсэн өргөдлийн шийдвэрлэлт нь дараах байдалтай байна. /Хүснэгт № 11/

2003-2017 онд иргэдээс ирүүлсэн өргөдлийн судалгаа

Хүснэгт №11

№	Үзүүлэлт	Анх ирүүлсэн		Шийдвэрлэсэн		Үүнээс шийдвэрлэгдээгүй	
		Шинээр өмчлөх	Эзэмшиж буй хашааны газраа өмчлөх	Шинээр өмчлөх	Эзэмшиж буй хашааны газраа өмчлөх	Шинээр өмчлөх	Эзэмшиж буй хашааны газраа өмчлөх
1	Өргөдлийн тоо	15841	2954	14245	2508	1596	446

Дээрх судалгаанаас харахад нийт ирүүлсэн өргөдлийн 89 хувийг хууль тогтоомжид заасны дагуу бүрэн шийдвэрлэн, иргэдэд газрыг өмчлүүлсэн байна. Харин 11 хувийг нь шийдвэрлэх боломжгүй байсан ба энэ нь дараахь шалтгаантай байна. Үүнд:

- Бүрдүүлэх баримт материал дутуу
- Хуулиар олгосон эрхийн хүрээнд газар өмчилсөн
- Хамтран өмчлөх эрхээ шилжүүлээгүй
- Хамтран өмчлөх эрхээ худалдсан, өвлүүлсэн, бэлэглэсэн, бусдын өмчлөлд шилжүүлсэн боловч хууль тогтоомжид заасны дагуу бүрдүүлэх баримт дутуу
- ГХГЗЗГ /хуучин нэрээр/-ын даргын 2011 оны 211 тоот тушаалаар батлагдсан “Иргэнд газар өмчлүүлж, кадастр хийх журам”-ын 3.1.5 заасны дагуу “гэр бүлийн хэрэгцээнд нэг удаа үнэ төлбөргүйгээр газар өмчилж авах эрхээ хэрэгжүүлсэн эсэх талаар лавлагаа авах” гэж заасан материал дутуу
- ГХГЗЗГ /хуучин нэрээр/-ын даргын 2008 оны 133 дугаар тушаалын 01 дүгээр хавсралтаар батлагдсан өргөдлийг бөглөж өгөөгүй зэрэг шалтгааны улмаас тухайн өргөдлийг холбогдох иргэнд уламжлан газар өмчлөх хүсэлтийг буцаасан байна.

3.1 Хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд холбогдох албан тушаалтан газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна.

Газрын тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-д “...газрын нэгдмэл санг эзэмших, ашиглах, хамгаалах болон газрын тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтэд ..., аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ, түүний тэргүүлэгчид, Засаг дарга хууль тогтоомжид заасан эрх хэмжээнийхээ дагуу хяналт тавина” гэж заажээ.

Аймаг, сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал:

Газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас 2015-2017 онуудад Айраг, Даланжаргалан, Өргөн сумдад хяналт тавьж ажиллаагүй байна.

Харин Айраг, Даланжаргалан сумдын ИТХ-ын тэргүүлэгчид, БОБ мэргэжилтэн, газрын даамлуудтай хамтран 2015 онд сумын газар нутагт хилийн цэс тогтоох ажлыг зохион байгуулснаас өөр хяналт шалгалтын ажлыг зохион байгуулаагүй байна.

Аймаг, сумдын Засаг дарга:

Аймгийн Засаг даргын 2017 оны А/60 дугаар захирамжаар уул уурхайн байгууллагын үйл ажиллагаанд байгаль орчин, ашигт малтмал, газрын харилцааны тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтийн байдалд хяналт шалгалт хийх ажлын хэсгийг аймгийн МХГ-ын байгаль орчин, ГГЗЗ-ын хяналтын улсын байцаагч, аймгийн ГХБХБГ-ын холбогдох мэргэжилтэнүүдийн бүрэлдэхүүнтэй томилсон байна.

Энэхүү ажлын хэсэг нь 2012-2016 онд газрын харилцаатай холбоотой гарсан сумын Засаг даргын захирамж, нэгж талбарын хувийн хэрэг, газрын дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтын баримт материал, зарим газар эзэмшигч, ашиглагч нар газар эзэмших, ашиглахаар байгуулсан гэрээнд заасан үүргээ биелүүлж байгаа эсэх, төрийн захиргааны байгууллагаас хяналтыг хэрэгжүүлж буй эсэхэд хяналт шалгалт хийжээ. Мөн уг шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ авч ажиллах тухай албан бичгийг сум тус бүрт хүргүүлэн ажиллажээ.

Мөн аймгийн ГХБХБГ-аас 2018 оны 04 дүгээр сарын 24-28-ны өдрүүдэд Айраг, Даланжаргалан сумдад 2017 оны газар зохион байгуулалтын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, иргэдэд газар зохион байгуулалтын үйл ажиллагааг сурталчлах, таниулах, газар эзэмших, ашиглах гэрээ дүгнэх, өмчлөл, эзэмшил, ашиглалтын газрыг хүлээлгэн өгөх, байрзүйн зураг болон мэдээллийн сангийн шинэчлэлт, нөхөн бүрдүүлэлт хийх зэрэг ажлуудыг зохион байгуулжээ.

Харин сумдын Засаг дарга нар дээрх ажлын хэсгийн шалгалтын мөрөөр арга хэмжээ авч ажиллах тухай хийгдсэн үйл ажиллагаанаас өөр тодорхой ажил зохион байгуулаагүй, гаргасан шийдвэрийнхээ биелэлтэд хяналт тавьж ажиллаагүй байна.

Мэргэжлийн хяналтын газар:

Газрын тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2-т “ ... газрын тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтэд тавих мэргэжлийн хяналтыг хууль тогтоомжийн дагуу эрх олгогдсон мэргэжлийн байгууллагууд хэрэгжүүлнэ” гэж заасан байна.

Аймгийн МХГ-аас тус байгууллагын тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 2015 онд Айраг, Даланжаргалан сумд, 2016 онд Өргөн сумын газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шалгалтын ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Мөн илэрсэн зөрчилд дараах зөвлөмж, хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг хүргүүлж, Өргөн сумын Засаг даргад албан шаардлага тогтоон ажилласан байна. Тус байгууллагын илрүүлсэн нийтлэг зөрчлөөс дурьдвал дараах байдалтай байна. Үүнд:


- Хууль эрх зүйн зөрчилтэй шийдэрүүдийг хүчингүй болгох.
- Газрын тухай хууль тогтоомжид заасан холбогдох ажлуудыг зохион байгуулах, газрын төлбөр ногдуулалтад хамруулах.
- Эзэмшил газраа 2 жил дараалан ашиглаагүй эзэмшигч, ашиглагч нарт хууьд заасны дагуу хариуцлага тооцож, газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээг хүчингүй болгох.
- Төрийн захиргааны байгууллагаас тавих хяналтыг сайжруулах.
- Сумын Засаг даргын газар давхар олгосон тухай захирамжийг хүчингүй болгох

Хуулиар олгосон эрхийн хүрээнд газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаагүй аймгийн ИТХ, Айраг, Даланжаргалан, Өргөн сумдын ИТХ, Засаг дарга нарт зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.


3.2 Иргэд, олон нийтэд газрын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг мэдээлж ажилласан байна.

Газар зохион байгуулалттын үйл ажиллагаатай холбоотойгоор иргэд, олон нийтэд аймаг, сумын ИТХ, ЗДТГ, ГХБХБГ-ын цахим хуудас, Facebook хуудас, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээллийн ил тод байдлыг хангаж ажилласан байна. Тухайлбал:


- Аймгийн Засаг дарга, ГХБХБГ-аас газрын дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалттай холбоотой мэдээллийг ГЗБГЗЗГ-ын газрын биржийн цахим системд, газар зохион байгуулалттай холбоотой төлөвлөгөө, хийж гүйцэтгэсэн ажлын зурагт тайлан, иргэдэд зориулсан хууль эрх зүйн зарим заавар, зөвлөмжийг аймгийн ЗДТГ-ын web site, орон нутгийн телевиз, байгууллагын Facebook хуудсуудаар дамжуулан иргэдэд мэдээлсэн байна.



- Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг, баталсан тогтоолын хамт мөн тус байгууллагын web site-д байршуулж, мэдээлсэн байна.



- Айраг, Даланжаргалан, Өргөн сумдуудын газар зохион байгуулалттай холбоотой мэдээллийг сумын ЗДТГ-ын мэдээллийн самбар, Facebook хуудсаар дамжуулан иргэдэд мэдээлсэн байна. Мөн багийн иргэдийн нийтийн хурал, нээлттэй хаалганы өдрөөр хууль, тогтоомж сурталчилан таниулах ажлыг зохион байгуулсан байна.



АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох баримт, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

- Сумдууд газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөг тухайн жилд хэрэгжүүлж, төлөвлөгөөний гүйцэтгэлийг хангаж ажиллаж байна.
- Худалдаа, үйлдвэрлэл, үйчилгээний газарт байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийгдээгүй байна.
- Төсөл сонгон шалгаруулалтаар эзэмшүүлэх газрын үнийг тооцох аргачлал батлагдаагүй хэвээр байна.
- Төсөл сонгон шалгаруулалт, дуудлага худалдааны үнийг орон нутгийн төсөвт бүрэн төвлөрүүлсэн байна.
- Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар эзэмшиж байгаа газрын зарим хэсгийг газар эзэмших гэрээнд заасан зориулалтын дагуу ашиглаагүй, зохих зөвшөөрөлгүйгээр гэрээнд заасан газрын хэмжээг хэтрүүлэн эзэмших зэрэг зөрчил илэрч байна.
- Зарим иргэн, ААНБ нь газар эзэмших эрх авч, гэрээ байгуулсан хэдий ч хуульд заасан хүндэтгэх шалтгаангүйгээр, гэрээнд заасан зориулалтын дагуу 2 жил болон түүнээс дээш хугацаагаар дараалан ашиглаагүй байна.
- Газар эзэмших гэрээг талууд жил бүр дүгнэх тухай хуулийн заалтын хэрэгжилт хангалгүй байна.
- 2017 оны жилийн эцсийн байдлаар тус аймагт гэр бүлийн хэрэгцээний газрыг үнэгүй өмчлөх тухай хуулийн хэрэгжилт 25 хувь байна.
- Гэр бүлийн хэрэгцээний газрыг нэг удаа үнэгүй өмчлөх тухай хуулийн заалтыг зөрчин 25 иргэнд 6.7 га газрыг давхардуулан олгосон байна.
- Газрыг өмчлөлийн зориулалтаар хуулиар тодорхойлсон хэмжээ, байршлыг баримтлан олгосон байна.
- Аймгийн ИТХ болон сумдын ИТХ, Засаг дарга нар хуулиар олгосон эрхийн хүрээнд газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаагүй байна.

Аудитаар илэрсэн зөрчилд нийт 1 албан шаардлага, 19 зөвлөмжийг холбогдох албан тушаалтанд хүргүүллээ.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ДАРГА С.ТҮМЭНБАЯР ТАНАА

1. Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1-д “Газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, гаргасан шийдвэрийнхээ биелэлтэд хяналт тавих ...” гэж заасныг хэрэгжүүлж ажиллах.

АЙРАГ, ДАЛАНЖАРГАЛАН, ӨРГӨН СУМДЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛД

1. Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1-д “Газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, гаргасан шийдвэрийнхээ биелэлтэд хяналт тавих ...” гэж заасныг хэрэгжүүлж ажиллах.

АЙРАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ Л.МӨНХЖАРГАЛ ТАНАА

1. Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2-т “Газар эзэмшигч, ашиглагчаас газар, түүний баялгийг хууль тогтоомж, гэрээний дагуу үр ашигтай, зохистой ашиглаж, хамгаалж байгаад хяналт тавих, зөрчлийг арилгах шийдвэр гаргаж, хэрэгжилтийг зохион байгуулах” гэж заасныг хэрэгжүүлж ажиллах.
2. Газрын тухайн хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2-т “Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар газар эзэмших эрх авсан иргэн, ААНБ нь 90 хоногт багтаан байгаль орчны нөлөөллийн үнэлгээг хийлгэсний дараа газар эзэмших гэрээ байгуулж, эрхийн гэрчилгээ олгоно, ...” гэж заасныг хэрэгжүүлж ажиллах.
3. Газар эзэмших гэрээнд зааснаас өөр зориулалтаар газар эзэмшиж байгаа 8 иргэний 0.2 га газрын асуудлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хянаж, шийдвэрлэх.
4. Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.6-д заасны дагуу 2 жил болон түүнээс дээш хугацаагаар үйл ажиллагаа явуулаагүй иргэн, ААНБ-ын газрын асуудлыг хуулийн дагуу шийдвэрлэх.
5. Газрын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.8-д “ ... гэрээний биелэлтийг талууд жил бүр дүгнэнэ” гэж заасныг хэрэгжүүлж ажиллах.
6. Эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр дур мэдэн өргөтгөл барин, үйл ажиллагаа явуулж байгаа иргэн О.Энхээгийн газрын асуудлыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу шийдвэрлэх.

ДАЛАНЖАРГАЛАН СУМЫН ЗАСАГ ДАРГА С.УРАНЦЭЦЭГ ТАНАА

1. Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2-т “газар эзэмшигч, ашиглагчаас газар, түүний баялгийг хууль тогтоомж, гэрээний дагуу үр ашигтай, зохистой ашиглаж, хамгаалж байгаад хяналт тавих, зөрчлийг арилгах шийдвэр гаргаж, хэрэгжилтийг зохион байгуулах” гэж заасныг хэрэгжүүлж ажиллах.

2. Газрын тухайн хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2-т “Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар газар эзэмших эрх авсан иргэн, ААНБ нь 90 хоногт багтаан байгаль орчны нөлөөллийн үнэлгээг хийлгэсний дараа газар эзэмших гэрээ байгуулж, эрхийн гэрчилгээ олгоно, ...” гэж заасныг хэрэгжүүлж ажиллах.
3. Газрын тухайн хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.6-д заасны дагуу 2 жил болон түүнээс дээш хугацаагаар үйл ажиллагаа явуулаагүй иргэн, ААНБ-ын газрын асуудлыг хуулийн дагуу шийдвэрлэх.
4. Газрын тухайн хуулийн 34 дүгээр зүйлийн 34.8-д “ ... гэрээний биелэлтийг талууд жил бүр дүгнэнэ” гэж заасныг хэрэгжүүлж ажиллах.
5. Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар эзэмшиж байгаа гэх иргэн Э.Мөнхзаяагийн 0.06 га газрыг асуудлыг хууль тогтоомжид заасны дагуу хянаж шийдвэрлэх.

ӨРГӨН СУМЫН ЗАСАГ ДАРГА Ж.СҮХБААТАР ТАНАА

1. Газрын тухайн хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2-т “газар эзэмшигч, ашиглагчаас газар, түүний баялгийг хууль тогтоомж, гэрээний дагуу үр ашигтай, зохистой ашиглаж, хамгаалж байгаад хяналт тавих, зөрчлийг арилгах шийдвэр гаргаж, хэрэгжилтийг зохион байгуулах” гэж заасныг хэрэгжүүлж ажиллах.
2. Газрын тухайн хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2-т “Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар газар эзэмших эрх авсан иргэн, ААНБ нь 90 хоногт багтаан байгаль орчны нөлөөллийн үнэлгээг хийлгэсний дараа газар эзэмших гэрээ байгуулж, эрхийн гэрчилгээ олгоно, ...” гэж заасныг хэрэгжүүлж ажиллах.
3. Газрын тухайн хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.6-д заасны дагуу 2 жил болон түүнээс дээш хугацаагаар үйл ажиллагаа явуулаагүй иргэн, ААНБ-ын газрын асуудлыг хуулийн дагуу шийдвэрлэх.
4. Газрын тухайн хуулийн 34 дүгээр зүйлийн 34.8-д “ ... гэрээний биелэлтийг талууд жил бүр дүгнэнэ” гэж заасныг хэрэгжүүлж ажиллах.
5. Сумын Засаг даргын 2015 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 58 дугаар захирамжаар иргэн А.Буяннэмэхэд газрын зориулалт өөрчлөн эзэмших эрхийг шилжүүлсэн асуудлыг хуульд заасны дагуу хянаж, шийдвэрлэх.

АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА Ц.ОЮУНСАЙХАН ТАНАА

1. Даланжаргалан сумын Засаг даргын 2005 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 39 дугаар захирамжаар иргэн Б.Болдбаатарт гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмчлүүлсэн газрыг хуульд заасан хэмжээг баримтлан дахин шийдвэрлэх.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



ДОРНОГОВЬ АЙМАГ ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Нутгийн удирдлагын ордон,

Утас/факс: (705) 2-30-03

E-mail: domogobi_mgl@yahoo.com

2018.07.05 № 3/282

танай _____ -ны № _____ -т

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Ч.АРИУНАА ТАНАА

Танай байгууллагаас ирүүлсэн “Газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилт” сэдэвт нийцлийн аудитын тайланг хүлээн авч танилцлаа.

Тус тайлантай холботой санал байхгүй болно.

ДАРГА

Б.ГАНЗОРИГ





**ДОРНОГОВЬ АЙМГИЙН
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ
БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум
Утас: 70523998

Э-шуудан: dornogovi@gazar.gov.mn

2018.07.06 № 562
танай _____-ны № _____-т

**Г ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН Г
АУДИТЫН ГАЗАРТ**

Газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хийсэн нийцлийн аудитын тайлантай холбогдсон санал байхгүй болно.

ДАРГА



Ц.ОЮУНСАЙХАН

071080



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2018 оны 07 сарын 09 өдөр

Дугаар А/17

Дорноговь аймаг, Сайншанд сум

Нийцлийн аудитын тайлан
баталгаажуулах тухай

Монгол Улсын Төрийн аудитын тухай хуулийн 04 дүгээр зүйлийн 4.1, 15 дугаар зүйлийн 15.2.2 дахь заалт, 19 дүгээр зүйлийн 19.1, 19.3.3 дахь заалт, Монгол улсын Ерөнхий аудиторовын 2017 оны А/188 тоот тушаалын V хавсралтын 2.4, “Нийцлийн аудитын түр журам”-ын 10 дугаар зүйлийн 02 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны бүтээгдэхүүн нийлүүлэх төлөвлөгөө, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын захиалгын дагуу гүйцэтгэсэн “Газрын тухай хуулийн хэрэгжилт” сэдэвт нийцлийн аудитын тайлан, 01/39 ДГА-2018/01/НА тоот албан шаардлагыг тус тус баталгаажуулсугай.

2. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2019 оны 01 дүгээр сарын 15-ны дотор ирүүлэхийг аймаг, сумдын Засаг дарга нарт тус тус зөвлөсүгэй.

3. Аудитын тайланг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, аймгийн Засаг дарга, ГХБХБ хэлтэс, Айраг сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Айраг сумын Засаг дарга, Даланжаргалан сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Даланжаргалан сумын Засаг дарга, Өргөн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Өргөн сумын Засаг дарга нарт тус тус хүргүүлсүгэй.

4. Зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежерийг түр орлон гүйцэтгэгч /Ц.Лүндэгмаа/-т үүрэг болгосугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

